



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
А.АРИУНЗАЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020 10 01 № 21

Асуулт тавих тухай

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхэд, гэр бүл, залуучуудын талаар баримтлах бодлого, хууль, эрх зүйн орчныг сайжруулахад онцгойлон анхаарч ажилласны үр дүнд хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг шинээр батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч сүүлийн үед нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл ихээр үйлдэгдэж, хүүхэд, эмэгтэйчүүд тэдгээрийн золиос болох явдал ихээр гарах боллоо.


Хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг асуудлуудад салбар хоорондын уялдааг сайжруулах, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, ард иргэдийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх шаардлага байсаар байгаа тул Улсын Их Хуралд “Хүчирхийлэлтэй тэмцэх лобби” бүлэг байгуулан ажиллаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.7-д тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Асуултын хариуг 2017-2020 оны байдлаар гарган ирүүлнэ үү.

1. Хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдлийн талаар хийсэн судалгаа, тайлан;
2. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл, тайлан;
3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээлэл, нөхцөл байдлын үнэлгээ;
4. Хүүхдийн тусламжийн утасны ашиглалт, тоон мэдээлэл;
5. Хүүхдийн эрхийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, баримталж буй бодлого;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАЯРСАЙХАН

2020000040